

Манмин Мэдээ

№ 61 2018 оны 6 сарын 24

61 орны хэлээр орчуулагдан эрч хүчтэйгээр түгээгдэх авралын зар, Ариун сайн мэдээ ба эрх мэдэлт хүчийг дамжуулан түгээх “Манмин Мэдээ” сонины 31 жилийн ой



Зургийн тайлбар: Дэлхий даяарх үй олон хүмүүсийг авралын зам руу удирдаж буй хэвлэл нийтлэлийн өнөөгийн байдал



▲ 33 орны хэлээр хэвлэгдэн гарах олон орны Манмин Мэдээ сонин

Амийн үг болон эрх мэдэлт хүчний гэрчлэлээр дүүрэн дэлхийн даяарх үй олон авралын зам руу удирдаж буй “Манмин Мэдээ” сонин 31 жилийн ой тохиож байна. “Манмин Мэдээ” сонин 1987 оны 5-р сарын 17 ны өдөр анхны дугаараа гаргаснаас хойш, 1991 оны 1-р сараас англи хэл дээр хэвлэгдэж эхлэсэн юм. Манмин төвийн сүмийн

30 жилийн ой тохиох 2012 оны 11-р сараас интернэтээр (www.manminnews.com) хаягаар цахим хэлбэрээр гардаг болсоноос хойш солонгос хэл төдийгүй англи, хятад, япон, орос, испани, монгол, хинди, араб, еврей зэрэг 33 орны хэлээр бүх дэлхий даяар тараагдаж байна.

Одоо байдлаар тухайн нөхцөл байдлаас хамаарч долоо хоног, 14 хоног, сар тутамд олон орны хэлээр нийтлэгдэх Манмин Мэдээ нь юуны түрүүнд И Жей руг пасторын амийн сургаал болон төрөл бүрийн сэдвээр Эзэний зүрх сэтгэлийг дуурайх арга замыг заах тусгай сургамжит булан, Бурханы хайр болон эрх мэдэлт хүчийг мэдэрсэн солонгосын болон гадаад салбар сүмийн итгэгч нарын гэрчлэл болон мэдээ зэрэг авралын зар тараах төдийгүй итгэгч нарын итгэлийн өсөлтөд асар их хэмжээний хувь

нэмэр оруулж өгсөнөөр солонгосын болон олон орны уншигчдын хайр болон талархалыг хүлээсэн авралын зар түгээх хэрэгсэл болж байгаа юм.

Манай чуулган нь үүнээс гадна итгэлийн амьдралын тухай ном хэвлэл ч олон орны уншигчдын талархалыг ч хүлээсээр байна.

Дэлхий даяарх үй олон номлогч нар итгэгч нар урсгал чиглэл үл хамааран, И Жей руг пасторын итгэлийн амьдралын тухай номоор дамжуулан библид агуулагдсан Бурханы хүсэл болон Түүний зүрх сэтгэл, Эзэний хайрыг ухааран сүнс сэтгэлээр өөрчлөгдөн, өсөж Ариун Сүнсний хүч нөлөөг мэдэрч байгаа юм.

И Жей руг пастор нь библид дэх тайлагдахад бэрх, сүнсний гүн утга бүхий ишлэлүүдийг тайлахын маш их мацаг барилт болон залбирлаар Бурханаас зууран гуйсан юм. Түүний үр дүнд Бурханы хайр ба авралын төлөвлөгөө агуулсан “Загалмай үг” төдийгүй “Итгэлийн хэмжээ”, “Тэнгэрийн орон”, “Там”, “Сүнс,бие, сэтгэл”, “Хайр бол хуулийн төгс

биелэл”, “Эдгээрийн эсрэг хууль гэж үгүй” зэрэг одоо байдлаар 112 төрлийн номыг хэвлэн гаргасан бөгөөд нийт 61 орны 48 төрлийн номыг орчуулан гаргаснаар бүх дэлхийн хүн төрөлхтөнд мөнх амьдрал болон авралын зам руу удирдан байна.

Нөгөөтэйгүүр цахим хэлбэрээр эдгээр номууд нийтлэгдснээр Солонгосын Кеобу мунгү, Риди бүүкс, Интерпак зэрэг номын дэлгүүрүүдээр дамжуулан түгээгдэж, 58 орны хэлээр 518 төрлийн ном Амазон, Киндел, Эйфли, Айбүүкс, Гүүгл плей бүүкс зэрэг цахим номын сайт болон интернет дэлгүүрүүдээр маш хурдацтай түгээгдэж байгаа билээ.

Ялангуяа дэлхийн хамгийн томд орох интернэт номын дэлгүүр болох Амазон дот комос И Жей руг пасторын гэрчлэл ном “Миний итгэл, миний итгэлийн амьдрал 1,2” төдийгүй “Загалмай үг”, “Итгэлийн хэмжээ”, “Тэнгэрийн орон”, “Там”, “Сүнс,бие, сэтгэл” зэрэг номууд англи, франц, испани, португали, итали хэл дээрх цахим хэлбэрээр худалдаалагдаж байна.

Ертөнц ч дийлж чадахгүй ИТГЭМЖИТ НЭГЭН (2)

“Тэд хаанчлалуудыг эзэлж, зөвт байдлыг үйлдэн ... арслангуудын амыг хааж, галын хүчийг унтраан ... Зарим нь доромжлогдон, ташуурдуулсан ... хоосон тарчиг байн, зовж ад үзэгджээ. Тэдний хувьд дэлхий зохисгүй байжээ” (Еврей 11:33-38).



И Жей руг пастор

Өнгөрсөн дугаарт ертөнц ч дийлж чадаагүй итгэлээр галын хариулт авсан Елиа, өөрийн ард түмнийг аварсан Естер, үхлийн өмнө ч эвлэрээгүй Даниелын тухай үзэцгээсэн билээ. Агуу итгэлийн өвөг дээдэс нь Бурхан руу хандсан хайр болон сүнс талын эр зоригтойгоор ямар ч аюулын өмнө огтхон айж сүрдэж байсан удаагүй юм.

Энэ удаагийн дугаарт Эзэнтэй итгэлээрээ нэгдэж, энэ ертөнцийг ялсан шинэ гэрээний итгэлийн эш үзүүлэгчдийн тухай өгүүлэх болно.

1. Амиа ч зориулж чадах төгс итгэл

Шинэ гэрээний Иохан номын 6:53-55д “... Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй. Миний махыг идэж, цусыг уусан хүн мөнх амьтай бөгөөд Би түүнийг эцсийн өдөрт амилуулна. Учир нь Миний мах бол жинхэнэ хоол, Миний цус бол жинхэнэ ундаа мөн.” гэсэн байдаг.

Энд хэлж буй Хүний Хүүгийн мах ба цусыг идэж, ууна гэдэг нь ямар утгатай юм бол? Үг нь Бурхан бөгөөд (Иохан 1:1), Үг нь махан бие болж энэ газар дээр ирсэн тэр эрхэм бол Есүс юм. (Иохан 1:14). Түүнчлэн “Хүний Хүүгийн махыг иднэ” гэдэг нь Бурханы үг сургаалийг өөрийн хоол тэжээл болгон шингээх буюу сүнс талаар зүрх сэтгэл дэх хорон мууг хаян, сайн болон хайраар дүүргэн, өөрийн сэтгэлийг өөрчлөх, шинэчлэхийг хэлж байгаа юм. Мөн яг энэ л үед “Хүний Хүүгийн цусыг” хамтад нь уух ёстой бөгөөд энэ нь Бурханы үгийг сонсож суралцангаа

тэр үгийн дагуу үйлдэх “Дуулгавартай дагах” үйлс хамт байх ёстой.

Энэ мэт гэрэл дотор үйлдэх үед Эзэний цус биднийг бүх гэмээс цэвэрлэж (1 Иохан 1:7), итгэлээр өсөж төгс байдалд хүрэх боломжтой (Иаков 2:22). Бат итгэл болон дахин амилалтын найдвар, тэмүүлэл байдаг учир энэ газрын үйл явдалд зууралдахаас илүү өөрийн амь амьдралаа ч гэсэн Эзэний төлөө эрс шийдэмгий зориулж чадах төгс итгэлтэй болох юм.

Тэгээд энэ газар дээр түр зуур зовлон эдлэн, үхсэн ч үүний дараа өгөгдөх тэнгэрийн алдар нь амсаж байсан зовлон зохиуртай нь харьцуулшгүй агуу болохыг мэдэж итгэдэг учраас юм. Түүнчлэн бүх л зүйлээ зориулсан Эзэний хайрыг ухаарч, өөрөө ч Эзэний төлөө баяр хөөртэйгөөр амиа зориулж чадах юм.

2. Бүх амьдралаараа Бурханыг хайрласан итгэлийн эш үзүүлэгчид

1) Маш хүнд хавчлага болон амиа зориулах замаар явсан Эзэний шавь нар

Эзэний шавь нараас хамгийн түрүүнд амиа зориулсан Иаков нь Иоханы ах бөгөөд Херод хааны үед цаазаар авахуулсан. Эзэний хайртай шавь Петр маш чанд хавчлага амийн аюул дунд байсан ч эр зоригтойгоор сайн мэдээг тарааж байгаад цаг нь болоход загалмайд буруу харан цовдлогдон амиа зориулсан юм. Эзэний шавь Иохан нь Доминатиус хааны үед буцалж буй тостой тогоонд хаягдсан ч Эзэн оршихуй хамтдаа байснаар түлэгдэж үхээгүй учир эцэстээ Патм арал дээр цөлөгдөн, Илчлэл номыг тэмдэглэж үлдээсэн юм.

Энэ мэт Эзэний шавь нар маш хүнд хавчлага дарамт ба амиа зориулах замаар явах хүч нь Бурханы тэдэнд өгсөн итгэл, Эзэний хайр тэдний сэтгэлийг хөдөлгөж халуун хайраар энэ бүхнийг даван туулсан юм. Эзэний төлөө өөрийн бүх зүйлээ зориулж, амиа өргөхөд ч хайран биш учраас юм.

2) Харь улсад авралын зар тарааж байгаад цаазлуулсан элч Паул

Элч Паул бол төрөхдөө л Ромын эзэнт гүрний иргэний харьяалалтай байсан байсан ба тухай үеийн элит

гэр бүлээс гаралтай бөгөөд бүх талын дээд зэргийн боловсролыг төгс эзэмшсэн хүн байсан юм. Ийм тэрээр Есүс Христтэй уулзсанаас хойш өөрийн бүх зүйлийг хаяж, ямарч хүнд бэрхшээл дунд (2 Коринт 11:23-27) Эзэний бие болсон сүм чуулганы төлөө зовлон эдлэнэ гэдэг нь харин ч баяртай байсан юм. Олон нийтийн өмнө нүцгэлүүлэн ташуурдуулж, гүн шоронд хоригдож байхдаа ч Бурханыг магтаж (Үйлс 16:22-25), заримдаа хүмүүсээр чулуугаар шидүүлж, түүнийг үхсэн байх гээд хотын гадна ч хаягдаж байсан удаатай (Үйлс 14:19).

Тэгсэн ч элч Паул тэр замаар явж буй шалтгаан нь Бурханы хайрладаг учир юм (Ром 8:35-37). Өмнө нь сүм чуулганыг хавчин, эсэргүүцэж, Эзэнт итгэдэг хүмүүсийг барьж алж хорооход хамгийн түрүүнд явдаг өөртэй уулзаж өгч, Эзэний элчээр босгож өгсөн Бурханы ивээл асар том бөгөөд түүнд бүх зүрхээр талархдаг байсан юм.

Тэрээр амд бьдралаа харь үндэстнүүдэд итгэмжтэй үйлчлэн, авралын зар тарааж байгаад, толгойгоо авахуулсан ба тэрээр Эзэний энгэрт тэврүүлэх хүртлээ өөрийгөө Эзэн бүрэн зориулсан юм.

3) Дугуй стадионд маш хүнд хавчлагыг ялсан анхны чуулганы итгэгчид

Манай тооллын 64 онд Ромд асар том хэмжээний түймэр гарсан байдаг. Неро эзэн хаан Ромыг шинэтгэх бодлого явуулж, шинэ барилгуудыг барих гэж түймэр гаргасан цуу үг тарааж, тэр түймрийн хариуцлагыг христэд итгэгчид дээр буулгасан юм. Үүний улмаас олон христэд итгэгчид баривчлагдаж, эцэст нь дугуй стадионд тэднийг бөөгнүүлэн өлсгөлөн араатанд бариулж үхэхийг харах зугаа болгон Ромын иргэдэд үзүүлсэн юм.

Энэ үед эдгээр христэд итгэгчдийн ихэнх нь ямарч айдасгүйгээр амиа зориулсан юм. Зарим нь өөрийн сүнсээ Эзэнд даатган залбирч байгаад, зарим нь гар гараасаа барин тэнгэр рүү ширтэн чанга дуугаар магтан дуулж байгаад араатанд бариулж алдартай амиа зориулцгаасан юм.

4) Хавчлага дарамтанд сөхрөлгүй амиа зориулсан анхны чуулганы удирдагч нар болон Катакум дахь итгэгч нар

Манай тоололын 2-р зуунд Христэд итгэгчдийн хавчлага улам даамжирч, христэд итгэгчид олон нийтийн газраар явах нь ч хориотой болж, гудамжинд элдэв бүлэглэлийн хүмүүст чулуугаар шидүүлэх аюулын хамт мөн итгэлийн амьдралаар амьдрах ёстой байлаа. Ялангуяа чуулганы удирдагчид хандсан хавчлага дэндүү их бэрхшээлтэй болж байлаа.

Антиох чуулганы ахлагч Игнатуис Ромын Колейзимд арсланд бариулан амиа зориулж, элч Иоханы шавь Смирна чуулганы ахлагч Филлигаб нь Ромын цезарийн шахалт дарамтаар Эзэнийг үгүйсгүүлэх үед ч тэрээр ямарч аюулын өмнө өвдөг сөгдөлгүй эцэст нь амьдаараа шатаагдсан юм.

Христэд итгэгч нарын хавчлага өдөр ирэх тусам даамжирч удаан үргэлжилж байсан тул тэд газар доорхи хонгилын нийтийн оршуулга болох Катакумд хорогдон, хэзээ баригдан үхэхээ ч мэдэхгүй тавгүй байдал аюул дунд хэдэн жил, магадгүй арван жилүүдийг өнгөрүүлсэн байдаг.

Яг л үхэл дунд амьдрал мэт маш хэцүү байсан ч Эзэн рүү хандсан хайраар бүх зүйлийг тэсвэрлэсэн юм. Өдөр бүр залбирал ба магтаалаар Эзэний хайрыг санаж, түрүүж явсан ах дүүсийнхээ тэнгэрийн оронд эдэлж буй баяр хөөрийн тухай ярилцан, хүсэл тэмүүлэл дотор амьдарч байлаа.

Ромд христ итгэл хүлээн зөвшөөрөгдөхөөс өмнө болсон хамгийн сүүлчийн хавчлага бол үнэхээр хатуу ширүүн, хэрцгий байсан юм. Итгэгч нарын иргэний харьяалал хураагдаж, чуулгануудыг галдан шатааж, маш олон итгэгч нарыг болон чуулганы удирдагч ахлагч нарыг баривчилсан юм. Хоригдож буй ахлагч удирдагчдыг Ромын шүтээнд үйлчлэхийг шаардаж, эсэргүүцвэл маш хэрцгийгээр тамлан зовоодог байв. Энэ мэт маш хүнд хавчлага дунд амиа зориулагчдын ихэнхд нь өөрийгөө христэд итгэдэг итгэлээ үгүйсгэвэл амьд үлдэх боломж өгсөн юм. Гэвч тэд үхлийг сонгож, Эзэний төлөө амиа хүртэл зориулахад харин ч баярлаж байлаа.

Хайрт итгэгч та бүхэн, Ертөнц ч дийлээгүй бат итгэлээр Бурханыг баярлуулж, Бурхан Аавын хайрт хүүхдүүддээ өгөхөөр бэлдсэн бүх ерөөлийг авахыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

| Мөргөл | Цаг |
|-------------------------------|--------------------|
| Их мөргөл | Ням гариг 10:30 |
| Үдээс хойш мөргөл | Ням гариг 13:30 |
| Хүүхдийн цуглаан | Ням гариг 10:00 |
| 3 дахь өдрийн мөргөл | Лхагва гариг 18:00 |
| 5 дахь өдрийн мөргөл | Баасан гариг 22:00 |
| Эмэгтэйчүүдийн багийн цуглаан | Лхагва гариг 16:00 |
| Шинэ итгэгч нарын сургалт | Бямба гариг 14:00 |

Залбирлын цаг Цаг

| Ангилал | Цаг |
|------------------------|----------------------------|
| Даниел үүрийн залбирал | Даваа-баасан 5:00-6:00 |
| Даниел өдрийн залбирал | Даваа-баасан 9:00-10:00 |
| Даниел оройн залбирал | Өдөр бүр 18:30-20:00 |



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

Жинхэнэ ерөөлийн замаар удирдаж буй миний Бурхан Аав

И Сон ил сүмд үйлчлэгч (40нас, 2-р их бүлэг 19-р хэсэг)

Аавын минь компани дампуурснаар гэрийн байдал тогтворгүй болж сүнс сэтгэлээр ядуу болсон би 1995 оны ахлах сургуулийн 2-р ангид байхдаа сургуулийн найзын номлолоор Манмин төв сүмд анх ирсэн юм.

Тухайн үед би угийн итгэгч гэр бүлд төрсөн ч гэсэн Бурхантай уулзсан мэдрэмж байхгүй байсан ч И Жей руг тэргүүн пасторын амийн сургаал ба дагалдах эрх мэдэлт хүчийг хараад Бурханы оршин байгаа болон Есүс Христ л бидний аврагч болохыг илүү баттай итгэх болсон юм. Мөн зүүн талын чихний хэнгэрэг цоорч, чанга яригч (дефүзэр)-н шуугиан шиг чимээ байнга сонсогддог байсан ч тэргүүн пасторын залбирлаар эдгэрч агуу гайхамшигийг мэдэрч байлаа.

Үнэний талд зогссоноор ерөөлийн үүд нээгдэж

1999 оны 5-р сард гэртээ зурагт үзэж байгаад манай сүмийг гүжирдэж буй нэвтрүүлгийг хараад би шууд л сүм рүүгээ яаран гүйсэн юм.

Тухайн үед оюутан байсан тул мөн ийм тийм хичээл гэх шалтагаар итгэлийн амьдрал төдийлөн сайн биш байсан ч ийм зохион байгуулалттай гүтгэлэг нэвтрүүлгийг хараад би тэвчиж чадахгүй байлаа. Сүм болон хоньчноо хамгаалахыг хүсч буй сэтгэл минь харин ч халуун болж, хичээнгүйлэн айл эргэж, би байх ёстой газраа үүргээ гүйцэтгэсээр байлаа. Энэ бол хүний мэдээж хийх ёстой үйлдэл гэж бодож байлаа.

Тэгээд тэр нэвтрүүлгийн худал зохиомол гэдэг нь илэрхий болмогц тэр үйл явдал дуусч, түүний дараа манай гэрийнхэн маш их эд хөрөнгийн ерөөл авсан юм. Манай аав ээжийн эрхэлдэг хөгжмийн зэмсэг болон дагалдах хэрэгсэл зардаг дэлгүүрт нэр алдартай дуучид ирж байнгын үйлчлүүлэгч болсоноор маш их ерөөл ивээл авсан юм.

2006 онд би хуримаа хийсний дараа эцэг эхдээ тусалж эхлэсэн юм. Шинэ хөгжмийн зэмсэг хийх, засах мэргэжилтэй тул би хамгийн анх хийсэн хөгжимөө тэргүүн пастордаа бэлэглэж, “Соно” магтан дууг тоглож өгсөн юм. Тэргүүн пастор маш баярлаж, ерөөлийн залбирал хийж өгсөн юм.

Түүний дараа л жинхэнэ гайхамшиг бий болсон юм. Миний хийсэн хөгжмийг урлагын нэртэй хүмүүс бие биедээ бэлэглэдэг болж, захиалгаар хийж зардаг боллоо. Том том хөгжмийн дэлгүүрүүдээс захиалга орж

ирж, бөөнөөр нийлүүлдэг болж, мөн хоум шоффинг сайт эрхэлдэг компанитай л хөгжим дангаар нийлүүлэх хатуу гэрээ байгуулж, гадаад руу илгээдэг хөгжим үйлдвэрлэдэг компани болж өргөжсөн юм.

Сорилт дунд ч хамт байсан Бурханы хайрыг ухаарч

Тэгтэл ингэж эд баялагыг хөөцөлдөж, үнэний үг сургаалиар амьдарч чадаагүй тул том хэмжээний асуудалтай тулгарсан юм. Богино хугацаанд маш хурдацтай өсөж томорч байсан тул эргэн тойрны аж ахуйн нэгжүүд атаархан дургүйцсэнээр татварын болон гаалийн шалгалтад орсон юм. Тэргүүн пастораас манай гэр бүлийн төлөө компаний төлөө залбирал өгсөн юм.

2011 оны дундаас авахуулан 2 жилийн турш цагдаагийн газар байцаагдаж, эд хөрөнгөө битүүмжлүүлж, прокурорын үзлэг шалгалтад хүртэл орж зурагтаар хүртэл манай компаний том гэмт хэрэг хийсэн мэтээр орой 8 цагийн онцлох мэдээгээр хүртэл гаргаж байлаа. Гэхдээ энэ үйл явдал болохын өмнө тэргүүн пастор зүүдэнд үзэгдэж, мөн прокурорын үзлэгт орохын өмнө ч зүүдээр дамжуулан хариуцсан прокурорын царайг харуулж өгөөд бүх л буруу ойлголт хардалт тайлагдах талаар мэдүүлж өгсөн юм.

Үнэхээр зовиуртай урт хугацаа байсан ч гэм буруугүй гэж тогтоогдох үед өөрийн эрхгүй нулимс тогтохгүй урсаж байлаа. Миний амьдралын байр суурь бий болгож өгсөн нь ч мөн хамгаалж өгсөн нь ч тэргүүн пасторын залбирал байсан тул гүн гүнзгий талархах сэтгэл төрж байлаа.

Нэг хэсэг ертөнцийн зүйлийг дагаж сүмдээ очиж чадаагүй үед байсан ба сүмдээ сайн явж байгаад эргэн тойрны нөхцөл байдлаас хэд хэдэн удаа очиж чадаагүй тохиолдол их байсан. Харин олон хүмүүсийн төлөөх тэргүүн пасторын хязгааргүй хайр ба золиосыг хараад би сэтгэлдээ шийдвэр гаргаж, авсан ивээлдээ талархаж хариулах сэтгэлээр итгэлээр амьдрахаар шийдсэн юм.

Ялангуяа “2018 оны Бүлэг, хэсэг, багийн ахлагч нарын онцгой мөргөл”-д бэлдэн маш их өөрчлөгдсөн юм. Би хэсгийн дэд ахлагчийн хувьд их биш ч өргөл болон цаг зүрх сэтгэлээ Бурханы өмнө өргөсөн юм. Онцгой мөргөлийн онцгой дууг бэлдэхийг тулд ажлаа эрт дуусгаж, сүмд очих үед

ганцаараа 3н хүүхдээ бодон, хоёр хүүгээ дагуулан сүм дээр ирэх тохиолдол их байсан ба, Даниел залбирлын дараа нэмэлт төлөвлөн залбирал хийх өдөр дууний дасгалын дараа хүүхдүүдээ гэртээ хүргээд дахин сүм дээр ирдэг байлаа.

Өдөрт 4 цаг жолоо барин сүм рүү ирж очих замдаа надад ингэж айл эргэх багийнхаа хүмүүсийн төлөө үйлчлэх үүрэг өгсөнд талархаж, миний сэтгэлийг мэддэг Бурхан байгаа болохоор аз жаргалтай байлаа. Саяхан нөхөр минь өөрчлөгдөж байгаад баяртай байна гэсэн эхнэрийнхээ үгийг сонсоод тэр хугацаанд их л хэцүү байсан байх даа гэж бодоход сэтгэл өвдөж, өдий хүртэл хамт байж ирсэн эхнэртээ талархаж байлаа.

Бурхандаа өргөсөн сэтгэл нь ерөөлийн суваг болоод

3-р сарын 25 ны өдөр онцгой мөргөлийн өдөр тэргүүн пастораас ерөөлийн залбирал амсаны дараа гайхамшиг бий болсон юм. Онцгой мөргөлд бэлдэнгээ компаний ажил сайн хийж чадаагүй тул сэтгэл жоохон эвгүйхэн байсан ч Бурхан ерөөж өгсөн юм.

3-р сарын борлуулалт ерөнхийдөө энэ сард борлуулалт муу байдаг ч харин ч 1, 2-р сарынхаас 10%-р илүү байсан юм. Манай хөгжмийг авч зарж борлуулдаг дэлгүүрүүд хөгжмийг минь суртчилж, сургууль, сургалтын төвүүд хүртэл манайхтай холбогдогдож, онлайн цахим хэлбэрээр биднийг суртчилж байсан учраас юм. Халлелүяя!

Энэ төдийгүй онцгой мөргөлийн тэр өдөр орой нь аав ээж маань Каннам дүүрэг дэх Абгүжондуны байр руу бидний нүүж ороорой гэсэн юм. Би энэ оны эхээр л манай багт Каннам дүүрэгийн шинэ итгэгч их ирсэн тул тийшээ нүүж очоод багийн айл эргэлт хийхийг хүсч байсныг мэдсэн юм шиг тэгж хэлэх маш их гайхаж байлаа. Мөн айл эргэлт зориулагдсан 7 хүний зориулттай машинтай болсон зэрэг бүгдийг төлөвлөдөг агуу Бурханы хайрыг бялхам дүүрэн мэдэрсэн юм.

Би өөрийн авсан ивээлээ бодоход миний үйлс дэндүү өчүүхэн ч үүнийг хүртэл хүлээн авч, ерөөж өгсөн хайрын Ариун Гурвал Бурхандаа бүх талархал ба алдрыг өргөө. Мөн мөнх амийн замаар удирдаж байгаа хайрт тэргүүн пастордаа гүн талархал илэрхийлье.



Tel: 82-2-824-7107
www.gcnetv.org
webmaster@gcnetv.org



Tel: 82-2-818-7334
www.manminseminary.org
manminseminary2004@gmail.com




Tel: 82-2-818-7039
www.wcdn.org
wcdnkorea@gmail.com



Tel: 82-70-8240-2075
www.urimbooks.com
urimbook@hotmail.com

“Нөхрийн минь тархи судасны бөглөрөл ямар ч хүндрэлгүй эдгэрсэн”



И Хэ сүг сүмд үйлчлэгч (62 нас, 3-р бүлэг 24-р хэсэг)

2018 оны 3-р сарын 13 өдөр бид Европод аялаж байх зуур Швейцарийн Зермат гэх уулийн далайн түвшинээс 3100 метрт орших мөнх цаст оргилыг үзэхээр уулын гал тэргэнд суун өгсөж байх зуур юм. Миний нөхөр Им Сог гын итгэгчийн толгойн эргэж, бие нь тавгүйтэж эхлэсэн юм. Зүгээр өндөрлөг газрын биеийн хямрал гэж бодож байгаад буцаж байранд ирсэн толгой эргэж тавгүйтсэн байдал хэвээрээ л байлаа. Бид гэнэт яагаад ийм болсон талаар өөрсдийгөө эргэн харж залбирч эхлэсэн юм.

Дараагийн өдрийн өглөө аялалын компаний ажилтан нөхрийн бие нэг тал руугаа хазайж мурийсан байдлыг хараад шууд түргэн тусламж дуудсан юм. Түргэн тусламжийн эмч ирээд нөхрийн бие байдлыг үзтэл маш яаралтай эмнэлэгт хэрэгтэй гэсэн бөгөөд нисдэг тэргээр шуурхай зөөж эмнэлэгт хэвтсэн юм. Үг яриа ч нэвтрэлцэхгүй, таних хүн ч байхгүй харийн улсад бид бүхнийг зөвхөн Бурхандаа даатган залбирахаас өөр аргагүй болсон юм.

Рентген MRI зурагны хариу “Тархи судасны архаг бөглөрөл” гэж гарсан байв. Эмч нар маш хурдан арга хэмжээ авах хэрэгтэй гэж байгаа ч аялалын даатгал хамаарахгүй ба эмчилгээний төлбөр төсөөлсөнөөс хавьгүй их байсан тул хурдхан Солонгос руугаа буцамаар байна гэсэн бодолтой байв. Эмнэлэгийн зүгээс хориглож байсан ч “Эмнэлэгээс гараад ямар нэг юм тохиолдоход хариуцлага үүрэхгүй” амлалт бичигт гарын үсэг зуран эмнэлэгээс гарч, аялалын хөтөчийн тусламжтайгаар хөтөлбөрийг цуцалж буцахаар боллоо.

3-р сарын 16 өдөр 17 цагийн үед Швейцарийн Цюрихээс Инчоны онгоцны буудал хүртэл 8цагийн турш нисэн нутагтаа ирээд бид шууд эмнэлэг рүү явсан юм. Эмч бараг эмчилгээ хийлгээгүй ийм байдалтай онгоцонд удаан хугацаанд явж ирнэ гэдэг “гайхалтай” хэрэг гэсэн юм. Нөхөр маань эмнэлэгт байх зуураа түүний биеийн баруун тал нь саажиж,


баруун хөл гараа сайн хөдөлгөж чадахгүй болж сайн ярьж ч чадахгүй боллоо.

Тэгтэл 3-р сарын 19 өдөр эмнэлэгт эргэлтээр ирсэн сүмийн манай хэсгийн ахлагч тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12) аар залбирч өгсөний дараа нөхрийн бие тайвширч, маш хурдан тэнхэрч хэвийн байдалдаа орж байлаа. Хөл нь хөнгөрч, гарын тамир нь сэргэж, хэл яриа ч хэвийн болж эхлэв.

Эмч хэлэхдээ хичнээн хамгийн хурдан сэргэлээ ч зайлшгүй 6н сар болно гэж байсан ч эмнэлэгт хэвтээд 9 дэх хоног дээрээ буюу 3-р сарын 24 ны өдөр эмнэлэгээс гарсан юм. Хамгийн талархалтай нь ямар хүндрэл, саажилтын ул мөргүй төгс хэвийн болсон бөгөөд 4-р сарын 5 наас урьдын адил хэвийн ажилдаа явах болсон юм. Халлелуяа!

Энэ үйл явдлаар дамжуулан нөхөр минь архи уухаа больж, Бурханы өмнө дахин төрсөн амьдралаар амьдарна гэсэн юм. Манмины итгэгч гэдгээр минь сахин хамгаалж, бүх зүйлийг сайнаар хөтөлж удирдсан Бурхандаа бүх алдар талархалыг өргөө.

Зургийн тайлбар: MRI зураг (Залбирал авахын өмнө)



▲ Баруун тархины цагаан дээр судасны бөглөрөл харагдаж байгаа байдал

▶ Зүүн тархины хажуу талд судасны бөглөрөл харагдаж байгаа нь

“Библи дэх бүх асуултын хариултыг олсоноор миний амьдрал өөрчлөгдсөн”

Би пасторын гэрт төрж, багаасаа л сүмд явдаг байсан ч библийн тухай мэдэх асуултууд маш их бөгөөд юу нь зөв итгэлийн амьдрал болохыг ялгалгүй бүдэг бадаг байсан юм. 2008 оны нэгэн өдөр зурагтаа асааж Енласе ТВ (Enlace TV Испани хэлтэй христчин телевиз)-р И Жей руг пасторын “Загалмайн үг” сургаал гарч байлаа. Амар тайван сэтгэл хөдлөм мөргөлийн уур амьсгал дотор Бурханы үгийг дамжуулж буй пасторын даруу төлөв хүндэтгэлтэй байдлаас их ивээл авч өөр бусад сургаалиудыг үзэхээр сүмийн сайт руу орж үзлээ.

8-н орны хэлээр байсан уг сайтад талархалтай нь Испани хэл дээр байлаа. Сургаалийг бүгдийг нь сонсоод текстийг нь уншин дахин шинэчлэгдэж байгаа сургаалиудыг үзсээр байлаа. Ялангуяа “Тэнгэрийн орон” гэх сургаалийг сонссд үгээр илэрхийлэхийн аргагүй сэтгэл хөдлөсөн юм. Тэгээд үргэлжлүүлэн “Загалмай үг”, “Итгэлийн хэмжээ”, “Сүнс бие сэтгэл”, зэрэг төрөл бүрийн сургаалийн номуудыг

уншсан. Тэгэх тусам энэ нь 100% библид суурилсан Ариун Сүнсний бялхал дотор бичигдсэн гүн утга бүхий сургааль гэж баттай итгэх болсон юм.

“Тэнгэрийн орон”, “Там” номыг маш шимтэн уншиж, энэ мэт сүнсний ертөнцийн нууцыг тайлахын тулд И Жей руг пастор хичнээн их залбирал ба мацаг барьсан болохыг ухаарсан юм. Өөр хаанаас ч олж мэдэхийн аргагүй бал мэт амийн үгээр дамжуулан бүх л олж мэдэхийг хүсч байсан бүх зүйл тайлагдагдаж миний амьдрал ч өөрчлөгдөж эхлэв. Итгэлийн амьдрал халуун болж, залбирлын хүч өгөгдөж, Тэнгэрийн орны тэмүүлэл дотор илүү их хичээн ариун зүрх сэтгэлтэй болохын төлөө зүтгэж байна. Мөн И Жей руг пасторын айлдсаны дагуу өдөрт библийн нэг бүлэг уншиж, нэг ишлэл цээжлэхэд библийг бүтэн 4 удаа унших болсон юм.

2017 оны 2-р сард би интернетээр Манмин төв сүмд бүртгүүлсэн юм. Чили болон Солонгосын хооронд

12 цагын зөрөөтэй тул фейсбүүк, Юутубе зэргээр Манмин төв сүмийн мөргөл болон залбирлыг цагт оролцож байгаа билээ. Мөн долод хоног бүр сүмийнхээ итгэгч нарт “Загалмай үг”, “Итгэлийн хэмжээ” сургаалийн товчилбор, мөн бяцхан ном хийгээд библи сургалт явуулж байна. Үүний тулд итгэгч нар Амралтын өдрийн хэр сахиу тухай зэрэг сүнс талын маш олон зүйлийн суралцангаа үйлдэн ерөөл авч байна.

2018 оны 3-р сарын 19 нд үүрээр хэвлий хэсгээр маш хүчтэй өвдөн нойрноос сэрлээ. Тэргүүн пасторын залбирал хийж өгсөн гар алчуураар (Үйлс 19:11-12) гэдсэн дээр тавин, үнэний үг сургаалиас дутуу байгаа өөрийгөө эргэн харж гэмшин Бурханаас эдгээж өгөхийг гуйн залбиртал тэр даруй эдгэрсэн юм. Манмин төв сүм нь Бурханы амьдрал оршин байгаа байдал илрэн гардаг, Эзэний хайраар дүүрэн, Ариун Сүнсний хүч нөлөө хүчтэй гардаг дэлхий хамгийн шилдэг чуулган юм.

Манмины үйлчлэлээр дамжуулан Чили улсын бүх ард түмэнд авралын нөлөө өгөгдөж, итгэгч нарт сүнслэг өсөлтөөр өсөхийг хүсэн тэмүүлж байна.



Карлос Делгадо Пуентелба ах дүү (26 нас, Чили)

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

| Мөргөл | Цаг |
|------------------------|---------------------|
| Хүндэтгэлийн их мөргөл | Ням гариг 10: 30 |
| Үдээс хойшхи мөргөл | Ням гариг 11: 30 |
| 3 дахь өдрийн мөргөл | Лхагва гариг 18: 00 |
| 5 дахь өдрийн мөргөл | Баасан гариг 21: 30 |
| Хүүхдийн цуглаан | Ням гариг 09: 00 |
| Сурагчдын цуглаан | Бямба гариг 15: 00 |
| Залуучуудын цуглаан | Мягмар гариг 17: 00 |

залбирал цагийн хуваарь

| Ангилал | Цаг | Удирдагч |
|-----------------------|--------------------------|----------------------------------|
| Үүрийн залбирал | 05:00-06:00 | Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч |
| Өглөөний залбирал | Даваа-Баасан 09:30-10:30 | Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч |
| Оройн Даниел залбирал | Өдөр бүр 18:00- 19:30 | Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч |

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manmininen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин